



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/А/1

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/189 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Баян-Өлгий аймгийн Өлгий суман дахь "Өлгий" нисэх буудлын өргөтгөлийн барилгын ажил"-ыг хийж гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны  
дарга:

Л.Ганбат

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө  
оруулалт, захиалагчийн албаны Худалдан авах  
ажиллагааны тасгийн дарга)

Гишүүд:

З.Туяа

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Захиргаа,  
хүний нөөцийн газрын менежер)

Ц.Болдсүрэн

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Аж ахуйн  
үйлчилгээ, дулаан сантехникийн албаны Аж ахуй,  
барилга засварын хэсгийн дарга)

Ч.Чинбат

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Аж ахуйн  
үйлчилгээ, дулаан сантехникийн албаны Дулаан  
сантехник, агааржуулалтын хэсгийн ахлах инженер)

М.Оргил  
("Сэтгэл зүй судалгаа, мэдээллийн төв" Төрийн бус  
байгууллагын гишүүн (тохиролцсоноор))

Г.Цэрмаа  
("Үндэсний аж үйлдвэрлэлийн зөвлөл"-ийн гишүүн  
(тохиролцсоноор))

Нарийн бичгийн  
дарга:

Э.Энхжин  
(Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө  
оруулалт, захиалагчийн албаны Худалдан авах  
ажиллагааны тасгийн мэргэжилтэн)

2.Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо (Л.Ганбат)-нд, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Т.Батжаргал), Иргэний нисэхийн үндэсний төв (Н.Батсайхан)-д тус тус үүрэг болгосугай.

3.Тендер болон сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, тендерт оролцоход үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Дотоод аудитын албанд хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Э.Энхжин)-д даалгасугай.

ДАРГА



Ч.МӨНХТУЯА